



Хөтөлбөр-2 Коло-Вада Нэмэх хөтөлбөр нь хүний бие организмыг 3 үе шаттайгаар цэвэрлэх цэвэрлэгээний хөтөлбөр бөгөөд хүн өөрийн бие организмаа хэдий чинээ сайн цэвэрлэж чадна төдий чинээ эрүүл урт наслах боломжийг өөртөө нээж байгаа анхны алхам юм.

Энэхүү хөтөлбөрийг Канадын нэрт эрдэмтэн Альберт Зерр боловсруулан гаргасан юм. Тэрээр хүнсний нэмэлт тэжээлийн салбарт 30 гаруй жил ажилласан бөгөөд түүнийхээ 15 жилийг ходоод гэдэсний цэвэрлэгээний салбарт зарцуулан Хөтөлбөр-2 Коло-Вада Нэмэх нэртэй цэвэрлэгээний программыг бий болгосон хүн юм. Хүний бие организмыг энгийнээр цэвэрлэх аргуудын сул талыг арилган хүний бие организмын бүхий л хэрэцээг тооцон, өвчин үүсгэгч нян, бактер, шимэгчийн эсрэг үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг цэвэрлэгээнийхээ хөтөлбөрт оруулж өгснөөрөө онцлог юм.

НҮБ-н дэргэдэх Олон улсын мэдээлэл зүйн академийн дүгнэлтээр: Коло-Вадатай ижил төстэй буюу адилтгаж үзэх бүтээгдэхүүн сүүлийн 20 жил дэлхий нийтэд гараагүй байна гэжээ.

Хүн организмыа цэвэрлэх цэвэрлэгээний хөтөлбөрийг хэрэглэхээс өмнө эхлээд өөрийн бие махбодийн шингэн орчин, бодисын солилцооны хэвийн байдлыг ханган өөрт хэрэгцээтэй эрдэс бодисыг хангалттай авч, биеийн ерөнхий байдлыг цэвэрлэгээ явагдахад бэлтгэх зайлшгүй шаардлагатай. Коло-Вада нь хүний бие организмыг ямар нэгэн эмчийн хараа хяналтгүйгээр цэвэрлэхэд зориулагдсан программ юм. Программыг хэрэглэх явцад хангалттай хэмжээний шингэнийг уух ёстой. Энэ нь бусад төрлийн цэвэрлэгээнээс ялгагдах нэг онцлог юм. Учир нь ус эмчилгээний гол хүчин зүйл нь болдог байна. Цэвэрлэгээний явцад гардаг ихэнх хүндрэлүүд нь организмд ус дутагдсантай шууд холбоотой байдаг. Ачаалал нь хүний бие организмын усны тэнцвэрийг зохицуулж байдаг эрхтэнүүд дээр очиж хүндрэл учруулж байдаг. Өөрөөр хэлбэл тунгалагийн тогтолцоо, арьс, бөөр давсаг, ходоод гэдсэнд их хэмжээний ачаалал очно гэсэн үг юм. Ийм учраас ямар ч цэвэрлэгээний явцад өөрийн биед шаардлагатай хэмжээний усыг хэрэглэх хэрэгтэй.

Коло-Вада нь хүний бие организмыг 3 үе шаттайгаар 14 хоногийн хугацаанд цэвэрлэдэг хөтөлбөр юм.

1. Бие организмыг бэлтгэх үе. 7хоног. Хоол боловсруулах эрхтэнүүдийн энгийн цэвэрлэгээ явагдахаас гадна бүдүүн гэдэсний хананд наалдаастай байгаа шаар, шавхдас, баасны чулуу зэргийг дэвтгээж зөөллөн, гэдэсний хананаас хөндийрүүлэх үйл ажиллагаа явагдана. Энэ үед нэг гэсэн дугаартай жижиг пакет бүхий олон төрлийн бэлдмэлүүдийг нэг дор хоол цай идэж уухаасаа 1-1,5 цагийн өмнө 250-300 мл усаар даруулан өглөө нэг пакетыг орой нэг пакетыг ууна. Түүнээс гадна 1-1,5 л Шүрэн кальцитай усаа өдрийн турш ууж алдагдаж буй шингэнээ нөхнө.

2. Организмын гүн цэвэрлэгээний үе. 4хоног. Энэ үед хоол боловсруулах эрхтэнүүд бүрэн цэвэрлэгдэхээс гадна гэдэсний ханан дахь шаар, шавхдас, баасны чулуу зэрэг нь хиа мэт уутлагдаад гадагшлах болно. Энэ үед хоёр гэсэн дугаартай пакет бүтээгдэхүүнийг дээрхийн нэг адил ууна. Мөн Коло-Вада Микс нэртэй коктейлийг бэлтгэн ууна. Түүнийг бэлтгэхдээ нэг стакан шүрэн кальцитай усанд эсвэл нэг стакан хүйтэн соконд хийж маш хурдан хутгаад ууна. Хэсэг хугацаа өнгөрсний дараа 200 мл

усыг араас нь уух хэрэгтэй. Цэвэрлэгээний үе явагдаж байх явцад өдөрт 2 л Шүрэн кальцитай усыг уух ба усны тэнцвэрт байдлаа хангахын тулд өдөрт нэмж 0,5 л усыг заавал уух нь зүйтэй.



3. Бие организмыг шаардлагатай тэжээлийн бодисоор хангах үе. Хүний бие организмын хэвийн үйл ажиллагааг бүрэн хангах тэжээлийн бодисууд агуулсан бүтээгдэхүүнийг хэрэглэснээр эрхтэн системүүдийн хэвийн ажиллах эхлэл тавигддаг. Гурав гэсэн дугаартай пакет бүтээгдэхүүнийг мөн дээрхийн адил усаар даруулан ууна. Өдрийн турш 1,5 л Шүрэн кальцитай усаа уусаар байх нь зүйтэй.

Коло-Вадаг хэрэглэснээр:

- Биеийн эд эс, эрхтэнүүдийг шимэгч хорхой, нян, вирус, мөөгөнцөр, хүнд металл болон химийн хорт бодисоос цэвэрлэнэ.
- Элэг бөөр, нойр булчирхай, зүрх судасны үйл ажиллагаа эрс сайжирч амьсгалахад уужим чөлөөтэй болно.
- Харшлууд эрс багасах буюу зарим нь алга болно.
- Үе мөчний үйл ажиллагаа сайжирч сэргэнэ.
- Биеийн дархлаа, бэлгийн булчирхайн үйл ажиллагаа сайжирна.
- Архаг өвчнүүдийн зовиур шаналгаа багасна.
- Толгойн өвдөлт багасах буюу бүр зогсоно.
- Биеийн илүүдэл жин буурна.
- Биеийн эрчим хүчний хангамж сайжрах зэрэг үр дүнгүүд гардаг.

Коло-Вада программын бусад цэвэрлэгээний программуудаас ялгагдах давуу талууд

1. Коло-Вадагийн бүрэлдэхүүнд шимэгчийн эсрэг бүтээгдэхүүнийг оруулж өгсөн бөгөөд организмыг шимэгчдээс хамгаалахад онцгой тустай. Хүн бүр жилд 2-с доошгүй удаа шимэгчээс урьдчилан сэргийлэх

программыг ууж байх хэрэгтэй.

2. Мацаг барьж цэвэрлэх нь эрт дээр үеэс хүмүүсийн амьдрал ахуйдаа хэрэглэж ирсэн арга бөгөөд энэ нь тийм ч төгс арга биш юм. Учир нь энгийн цэвэрлэгээ явагдаж, бие организм дахь ашигтай бодисууд гадагшилж, тэжээлийн бодисуудын дутагдалд орох зэрэг олон сөрөг нөлөө үзүүлдэг. Хамгийн чухал нь өлсөхдөө байгалийн хуулийг дагаж, бие организмынхаа хэрэгцээг зөв тооцох ёстой юм. Доктор Альберт Зерр энэ бүхнийг маш сайн тооцсон. Тэрээр мацаг барих үеийн бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд каолин/нунтаг цагаан шавар/-г оруулсан байдаг. Энэ нь хэд дахин томорч хөөх чадвартайгаас гадна шингээгчийн үүргийг сайн гүйцэтгэж бие организмд хуримтлагдсан хорт бодисуудыг өөртөө шингээн гадагшилдаг байна.

3. Программын бүрэлдэхүүнд ферментүүд болон амьд ашигтай бактер агуулсан бүтээгдэхүүнүүдийг оруулсан явдал юм. Эрдэмтэдийн судалгаагаар хүмүүсийн 80% нь амьд ашигтай бактерийн тэнцвэр алдагдаж, ферментийн дутагдалд орсон байдаг байна.

4. Коло-Вадад энзиматик-цэвэр ургамалын гаралтай ферментийг оруулж өгсөн байдаг нь богино хугацаанд ферментүүдийн үйл ажиллагааг сэргээхэд оршино.

Хүний аливаа эрүүл мэндийн асуудал нь бүхэлдээ бие организмын бохирдол, хэрэгцээт шим тэжээлийн дутагдал гэдэгтэй л холбоотой байдаг. Бид түрүү түрүүчийн мэдээллүүдээс бие организм 7 үе шатлалтайгаар бохирдож байдаг. Бохирдол гэдэг нь маш өргөн хүрээтэй асуудал болохыг ойлгож авсан. Бохирдол гэдэгт бактер вирус шимэгч мөгөнцөрүүд ч орох бөгөөд эрүүл мэндийг нөхөн сэргээхэд организмын бохирдол, хордлогыг тайлах гэдэг асуудал нэн чухал байр суурийг эзлэдэг.

Ийм учраас БИХНБ-г хэрэглэхдээ биеийн шингэн орчноо эрүүлжүүлж, эрдэс кальциар хангах, бүх бактер вирус шимэгчдийн эсрэг арга хэмжээ авах, бие организмын гүн цэвэрлэгээг хийх гэсэн дарааллаар эхэлж, тухайн хүний биеийн байдал эрхтэн системийн үйл ажиллагааг дэмжих нөхөн сэргээх асуудлыг шийддэг

Гэтэл манай нөхцөлд гадаадын маш олон компаний байгалийн натурал бүтээгдхүүнтэй бие даасан сүлжээнүүд ажиллаж байгаа. Тэд ихэвчлэн эрүүл мэндээ хамгаалах хадгалах зориулалттай тэжээлүүд гол төлөв байдаг бөгөөд ямар нэгэн байдлаар цэвэрлэх цай ч юмуу цэвэрлэгээний бэлдмэлтэй байдаг ч тэр нь хоол боловсруулах зам, ходоод гэдэсний хөндийг бага зэрэг гүйлгэж туулгах төдий юм.

Харин биеийн гүн цэвэрлэгээ, эсийн төвшиний цэвэрлэгээ, тунгалгийн тогтолцооны цэвэрлэгээ гэдэг бол өөр асуудал юм. Үүнийг анхаараагүйгээс зөвхөн тэжээлээр нэг хэсэгтээ гялалзахаас өөр үр дүнгүй бөгөөд зарим тохиолдолд сөрөг үр дүн өгөхийг үгүйсгэх аргагүй

Тэгэхээр та эрүүл мэндээ цогцсоор нь хандахыг хүсвэл эрүүл мэндийн төвшин тогтоох компьютер оношилгоонд орж, мэргэжлийн зөвлөхүүдэд хандах нь чухал юм.